



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.



Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдсан хэдий ч 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан зарим мэдээллүүдийг байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

УВААГ-2016/14-НА

2016 оны 12 дугаар сар

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн: Дарга, тэргүүлэх аудитор Б.Авирмэд Аудитын менежер Ж.Энхжаргал Аудитор М.Бат-Амгалан 2016 оны 12 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 7045-3721, 70453799 дугаарын утсаар харилцана уу. Хаяг: Увс аймгийн Аудитын газар Улаангом сум 3 баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг 1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдсан байна. Дүгнэлт Зөвлөмж Бүлэг 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээллээгүй байна. Дүгнэлт Зөвлөмж Бүлэг 3. Шилэн дансны хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна. Холбогдох байгууллагын санал Аудитын газраас өгөх тайлбар	4-6 7-8 9-11 12-13 13 14
--	---	---

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ.

Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх;
- Хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасан байгууллага үүргээ бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх;
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх;
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Хамарсан хүрээ

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнууд 2016 оны 3 дугаар улирлын байдлаар хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан эсэхийг хянан баталгаажууллаа.

Аудитад аймаг, сумдын төсөвт байгууллага, орон нутгийн өмчит аж, ахуйн нэгжийг хамрууллаа.

Арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 420, Төрийн хяналт, шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг явуулахад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримталж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур болгон ашиглав.

- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн актууд

Аудитыг 2016 оны 10 сарын 03-наас 12 сарын 15-ны хооронд аудитор М.Бат-Амгалан хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий зүйл

ҮАГ-ын нэгдсэн удирдамж, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2016 онд Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2 дахь удаагаа аудит хийж байгаа бөгөөд өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдалд анхаарал хандуулсан болно.

Аудитын батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан аудитын зорилт, дэд зорилтуудын хүрээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагуудад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж байгаа эсэх, тэдгээр байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх, 8 дугаар зүйлийн 8.2-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг аудитаар авч үзлээ.

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан нийт 186 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг хамруулаа.

2016 оны эхний улирлын байдлаар Увс аймгийн хэмжээнд төрийн өмчийн 35 төсөвт байгууллага, орон нутгийн өмчийн 140 байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн 3 газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа 7 компани, аж ахуйн нэгж 2016 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар shilendans.gov.mn сайтад бүртгэгдэж аудитад хамрагдсан бол 2016 оны 3 дугаар улирлын байдлаар төрийн болон орон нутгийн өмчит 186 байгууллага цахим хуудсан мэдээлэл байршуулж 1 дүгээр улирлын гүйцэтгэлтэй харьцуулахад 5 хувиар өссөн байна.

2016 оны 2, 3 улиралд Шилэн дансны цахим сайтад 7 байгууллага шинээр цэс нээж бүртгүүлсэн байна.

БҮЛЭГ 1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна” гэж заасан байна.

Дээрх заалтыг үндэслэн 2016 оны 9 сарын 30-ны байдлаар Увс аймгийн хэмжээнд 186 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд shilendans.gov.mn сайтад бүрэн бүртгүүлж, мэдээллээ оруулж байна.

Хуулийн үйлчлэх хүрээг графикаар үзвэл дараах байдалтай байна.



Өмнөх аудитаар Шилэн дансны цахим хуудсанд цэс нээлгээгүй байсан “Таван Тэсийн илч” ОНӨААТҮГ, Улаангом сумын 4 өрхийн эмнэлэг, Тариалан сумын Хархираа багийн Хүн эмнэлэг, Уурхай хүн эмнэлэг shilendans.gov.mn сайтад цэс нээлгэж бүртгүүлжээ.

2016 онд Засгийн газрын тогтоолоор зарим газар, хэлтсүүдэд бүтцийн өөрчлөлт хийсэнтэй холбоотой шилэн данс цахим хуудсанд нэг байгууллага давхардаж бүртгэгдсэн мэт харагдаж байна. Тухайлбал:

- Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс 2 нэгдэж Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болсон,
- Аймгийн ИТХ-д харъяалагдаж байсан Орон нутгийн өмчийн алба, Худалдан авах ажиллагааны алба нэгдэж Орон нутгийн өмчийн газар болж өөрчлөгдсөн ч шилэн данс цахим хуудсанд дээр 3 нэрээр давхар цэс бүртгэлтэй байна.

- Улсын бүртгэл, статистикийн газар нь Статистикийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс болж өөрчлөгдснөөр Улсын бүртгэл, статистикийн газрын мэдээллийг харах боломжгүй байна.

Шилэн данс цахим хуудсанд хуулийн 3 зүйлийн 3.1.1-д заасан байгууллагуудаас зарим байгууллагын мэдээлэл оруулах цэс дутуу байгаагаас хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн оруулах боломжгүй байна. Тухайлбал:

- Шилэн данс цахим хуудсанд 4 өрхийн эмнэлэгийн зөвхөн улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээллийг оруулахаас өөр цэс байхгүй байна.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. “Таван Тэсийн илч” ОНӨААТҮГ, 4 өрхийн эмнэлэг, 2 багийн эмнэлгийг Шилэн данс цахим хуудсанд цэс нээлгэж, мэдээллийг байршуулах боломжтой болсон байна.
2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан нийт 186 төсөвт байгууллага, аж ахуйн нэгж Шилэн дансны тухай хуулийн дагуу shilendans.gov.mn сайтад хамрагдсан байна.
3. Шилэн данс цахим хуудсанд зарим байгууллагын нэр давхардаж бүртгэгдсэн байна.
4. Шилэн данс цахим хуудсанд 4 өрхийн эмнэлгийн хуулийн дагуу мэдээллүүдийг оруулах цэс дутуу байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллагад зөвлөж байна. Үүнд:

ЗДТГ-ын Санхүү хяналт, дотоод аудитын албаны дарга М.Энхболд танаа:

1. Шилэн данс цахим хуудсанд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Орон нутгийн өмчийн алба, Худалдан авах ажиллагааны алба, Орон нутгийн өмчийн газар гэсэн давхар цэс нээсэн байгааг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх.
2. Шилэн данс цахим хуудсанд 4 өрхийн эмнэлгийн хуульд заасны дагуу мэдээлэл оруулах боломжийг хангаж цэсийг бүрэн оруулах.

БҮЛЭГ 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 зүйлийн 6.1-д заасны дагуу 2016 оны 3-р улирлын байдлаар дараах мэдээллийг бүрэн оруулсан байхаар тусгасан байна. Үүнд:

- 6.1.2. хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;
- 6.1.3. дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;
- 6.1.4. жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 сарын 15-ны өдрийн дотор;
- 6.1.5. төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 07-ны өдрийн дотор;
- 6.1.6. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр;

Гэтэл Увс аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар хамрагдсан 186 байгууллагууд shilendans.gov.mn сайтад дээрх мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна. Тухайлбал:

- 6.1.2-д заасан мэдээллийг хуулийн дагуу нууцад хамаарах 3 байгууллага, цахим хуудсанд цэс байхгүйгээс оруулах боломжгүй 4 байгууллага, мэдээлэл оруулаагүй 1 байгууллага,
- 6.1.3-д заасан мэдээлэлд хамааралгүй 9 байгууллага, дараа жилийн төсвийн төслийг 109 байгууллага мэдээлээгүй,
- 6.1.4-д заасны дагуу 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан бүх байгууллага байршуулаагүй, 2016 оны эхний хагас жилийн тайланг 132 байгууллага байршуулсан, 9 байгууллагад хамааралгүй, 45 байгууллага мэдээлээгүй,
- 6.1.5-д заасан мэдээллээс аудитын дүгнэлтийг 1 байгууллага оруулж, хамааралгүй 10 байгууллага, мэдээлээгүй 175 байгууллага, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, мэдээлсэн байгууллага 19, хамааралгүй 9, мэдээлээгүй 158 байгууллага,
- 6.1.6-д заасан мэдээллээс:
 - ✓ Төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааны тайлбарыг 102 байгууллага бүрэн байршуулсан, 7 байгууллага хамааралгүй, 78 байгууллага мэдээлээгүй байна.
 - ✓ Хандив тусламжийн хэмжээ түүний зарцуулалтыг 156 байгууллага байршуулсан, хамааралгүй 5 байгууллага, 25 байгууллага мэдээлээгүй,

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 6 сум байршуулсан, 13 сум мэдээлээгүй, бусад нь хамааралгүй, тусгай сангийн орлого зарлага, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг 4 сум, 1 байгууллага байршуулсан, 15 сум мэдээлээгүй, бусад нь хамааралгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллийг аудитад хамрагдсан байгууллагууд шилэн данс цахим хуудсанд бүрэн байршуулаагүй байна. Тухайлбал:

- 6.4.1, 6.4.2 дахь заалтыг 5 байгууллага мэдээлээгүй,
- 6.4.3-д заасан мэдээллийг 8 байгууллага байршуулаагүй, хамааралгүй 146 байгууллага байна. Мэдээлэл байршуулсан 32 байгууллагын тендерт нийт 208 аж ахуйн нэгж оролцсоноос шалгарсан 114, шалгараагүй 95 оролцогчийг тус тус мэдээллэсэн байна.
- 6.4.4-д заасан мэдээллийг 5 байгууллага байршуулаагүй, 136 байгууллагад 5 саяас төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт хийгдээгүй, 44 байгууллагад 4777,9 сая төгрөгийн нийт 284 худалдан авалт хийгдснээс 1050,0 сая төгрөгийн дүн бүхий 75 худалдан авалтын гүйлгээг мэдээлээгүй,
- 6.4.5 дахь заалтад 64 байгууллага хамааралгүй, 2 байгууллага мэдээлээгүй, 120 байгууллага 8920,0 сая төгрөгийн 346 зарлагын гүйлгээнээс 1273,0 сая төгрөгийн 137 гүйлгээг мэдээлээгүй, 5 саяас төгрөгөөс дээш орлогын гүйлгээг 5 байгууллага мэдээлээгүй, 144 байгууллагын 44512,9 сая төгрөгийн 1406 орлогын гүйлгээнээс 7530,2 сая төгрөгийн 316 гүйлгээг мэдээлээгүй,
- 6.4.6, 6.4.7 дахь заалтуудад 8 байгууллага хамааралгүй,
- 6.4.8 дахь заалтад хамааралгүй 156 байгууллага, мэдээлэл байршуулаагүй 13 байгууллага, мэдээлэл оруулсан 17 байгууллагын 545.0 сая төгрөгийн 180 шийдвэр байршуулахаас 441.7 сая төгрөгийн 45 шийдвэрийг байршуулаагүй,
- 6.4.9 дэх заалтыг 26 байгууллага мэдээлээгүй байна.

Дээрх заалтад хамааралгүй байгаа байгууллагууд нь Нууцын тухай хуулиар тусгайлан заагдсан мэдээллийг Цэргийн ангиуд байршуулаагүй, өрхийн эмнэлгүүд цахим хуудсанд мэдээлэл оруулах цэс байхгүй, “Таван тэсийн илч” ОНӨААТҮГазар шилэн дансны цахим хуудсанд шинээр цэс нээснээс мэдээлэл оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан мэдээллийг орон нутгийн сонгуулийн дараа байгууллагын дарга, нягтлан бодогч нар өөрчлөгдөхөд мэдээллийг шинэчлэж оруулаагүй байна. Тухайлбал:

- Татварын хэлтэс, Цагдаагийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Хөгжимт драмын театр, Цогцолбор 2-р сургууль, Увс эрдэм ахлах сургууль, Чандмань Эрдэм сургууль, Тэс, Өлгий, Зүүнговь сумын зарим төсвийн байгууллагууд, Улаангом сумын 1,2,4,5,7 дугаар цэцэрлэгүүд гэх мэт

Дээрх зөрчлүүдийг арилгуулж, биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллах талаар албан тоот, зөрчлийн судалгааг аймгийн ЗДТГ-ын Санхүү хяналт, дотоод аудитын албанд хүргүүлээ.

Дүгнэлт :

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аудитад хамрагдсан байгууллагууд Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.
2. Шилэн данс цахим хуудсанд өрхийн эмнэлгүүдийн мэдээлэл байршуулах цэс дутуу байна.
3. Шилэн данс цахим хуудсанд хуулийн дагуу олон нийтэд мэдээллийг хүргэх үүрэг бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл үнэн зөв байршуулаагүй байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

ЗДТГ-ын Санхүү хяналт, дотоод аудитын албаны дарга М.Энхболд танаа:

1. Өрхийн эмнэлгүүдийн цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл оруулах боломжийг хангах.
2. Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг цахим хуудсанд бүрэн байршуулах арга хэмжээг авах.

Бүлэг 3

Шилэн дансны хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.2-д “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Увс аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын алба сар бүр shilendans.gov.mn сайтын мэдээллийг хянаж тухай бүр хүснэгт гарган тэмдэглэл хөтлөн, шаардлагатай нөхцөлд зөвлөмж арга зүйгээр ханган ажиллаж байгаа хэдий ч аудитад хамрагдсан байгууллагууд хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулаагүй байгаа нь хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасны дагуу аймгийн Аудитын газар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015 он, 2016 оны эхний улирлын байдлаар нийцлийн аудит хийж зөвлөмж өгснөөр хамрагдаагүй байсан байгууллагууд бүрэн хамрагджээ.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:

2016 оны 1-р улирлын байдлаар Шилэн дансны хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар дараах зөвлөмжүүд өгөгджээ. Үүнд:

1. Төсвөөс санхүүжилт авдаг хувийн хэвшлийн мэдээллийг шилэн дансны сайтад мэдээлэл байршуулах эсэхийг тодорхой болгох зөвлөмжийг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах байгууллагуудын түвшинд авч үзэн аудитын явцад “Таван тэсийн илч” ОНӨААТҮГ, 4 өрхийн эмнэлгүүдийг шилэн дансны цахим хуудсанд цэс нээлгэж, мэдээллийг байршуулсан байна.
2. Улс, орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг хувийн сургууль, цэцэрлэгүүд шилэн данс цахим хуудсанд цэс нээгээгүй байна.

Дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Увс аймгийн Санхүү хяналт, аудитын алба Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд сар бүр хяналт тавьж байгаа хэдий ч байгууллагууд цахим хуудсанд мэдээллээ бүрэн байршуулаагүй байна.

Зөвлөмж:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллагад зөвлөж байна. Үүнд:

Санхүү хяналт, дотоод аудитын албаны дарга М.Энхболд танаа:

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хяналтыг хийж биелэлтийг хангуулах.

Холбогдох байгууллагын санал



УВС АЙМГИЙН
НРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

213400, Улаангом, Увс аймаг

2016.12.15 № 330
танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайланд санал тусгах тухай

Аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Монгол Улсын Шилэн дансны тухай хууль" -ийн хэрэгжилтийг аймгийн хэмжээний 147 төрийн өмчит төсөвт байгууллага, 34 орон нутгийн өмчид төсвийн байгууллага 4 орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт явуулсан байна.

Уг нийцлийн аудитаар "Монгол Улсын Шилэн дансны тухай хууль" 3-р зүйлийн 3.1.1-д заасны дагуу байгууллагууд хамрагдсан эсэх, мөн хуулийн 6-р зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх, мөн хуулийн 5-р зүйлийн 5.3-д заасан үүргээ хэрэгжүүлж байгаа эсэх, мөн хуулийн 8-р зүйлийн 8.2-д заасан хяналтын үүргээ биелүүлж байгаа байдалд хяналт хийсэн байна.

"Монгол Улсын Шилэн дансны тухай хууль" -ийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын дүгнэлттэй санал нэг байна.

Тайлантай холбоотой гарсан зөвлөмжийг холбогдох албан тушаалтнаар хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА



Э.НАСАНБАТ

1 0130



УВС АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

213400, Улаангом, Увс аймаг
Утас/Факс: 7045-2012

2016.12.15 № 2/1316
таний _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын дүгнэлттэй санал нэг байна. Тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА



С.БАТЖАРГАЛ

2 2911

My.doc tamgin gasar -A5

**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Шилэн дансны хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан аймгийн ИТХ-ын 330 тоот, аймгийн ЗДТГ-ын 2/1316 тоот албан бичгүүдээр ирүүлсэн саналыг үндэслэн тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

М.БАТ-АМГАЛАН